



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/69/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: [oyunkherlenb@audit.gov.mn](mailto:oyunkherlenb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа .....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	14

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 319

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭРЛЭН СУМЫН 1 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.БАДРАА ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг цар тахлын хорио цээрийн нөхцөл байдлаас шалтгаалан дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020312



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>99,714,551.12</b>	<b>105,859,333.29</b>
33	АВЛАГА	00.00	2,639,052.17
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,639,052.17
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>99,714,551.12</b>	<b>103,220,281.12</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>153,900.00</b>	<b>533,700.00</b>
35130	Эм боох материал	153,900.00	533,700.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>99,560,651.12</b>	<b>102,686,581.12</b>
35410	Бичиг хэргийн материал	1,058,524.50	1,037,324.50
35420	Аж ахуйн материал	1,196,200.00	2,543,100.00
35460	Хүнсний материал	00.00	682,730.00
35470	Бусад хангамжийн материал	97,305,926.62	98,423,426.62
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>824,220,748.54</b>	<b>807,131,680.85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>824,220,748.54</b>	<b>807,131,680.85</b>
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>691,259,248.54</b>	<b>674,262,480.85</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	670,727,279.00	670,727,279.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,832,126.44	-35,499,234.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,640,189.50	56,986,665.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,896,003.90	-40,030,560.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,268,015.80	37,426,515.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,891,055.68	-32,432,935.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,358,000.00	22,322,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,115,049.74	-5,237,249.70
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>132,961,500.00</b>	<b>132,869,200.00</b>
39301	Програм хангамж	1,251,500.00	1,395,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,015,000.00	-1,251,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	132,725,000.00	132,725,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>923,935,299.66</b>	<b>912,991,014.14</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,639,052.17</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,639,052.17</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>2,639,052.17</b>
4136	Бусад өглөг	00.00	2,639,052.17
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	2,639,052.17
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>923,935,299.66</b>	<b>910,351,961.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>923,935,299.66</b>	<b>910,351,961.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408,530,130.97	408,530,130.97
51101	Өмч: - төрийн	408,530,130.97	408,530,130.97
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>49,702,178.77</b>	<b>36,118,841.08</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	49,702,178.77	49,702,178.77
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-13,583,337.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	465,702,989.92	465,702,989.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>923,935,299.66</b>	<b>912,991,014.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>446,379,745.00</b>	<b>333,089,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>138,324,045.00</b>	<b>5,248,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,355,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,355,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,355,000.00	00.00
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	131,969,045.00	5,248,500.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	131,969,045.00	5,248,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>22,160,100.00</b>	<b>16,755,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,895,600.00	311,086,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,698,000.00	140,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд ойлгогдсон	198,000.00	140,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,462,100.00	16,615,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	18,462,100.00	16,615,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>334,884,905.40</b>	<b>346,673,037.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>334,884,905.40</b>	<b>346,673,037.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	332,451,384.09	337,102,426.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	206,684,403.00	244,483,900.00
210101	Үндсэн цалин	172,198,562.00	189,280,738.49
210102	Нэмэгдэл	17,134,248.00	35,991,691.56
210104	Урамшуулал	17,351,593.00	19,211,469.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,023,485.69	32,095,358.69
210201	Тэтгэврийн даатгал	17,755,685.69	23,694,783.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,066,900.00	2,094,919.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,653,600.00	1,676,075.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,400.00	439,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,133,900.00	4,189,937.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,921,110.00	11,435,925.00
210301	Гэрэл, цахилгаан	4,204,231.00	2,834,883.00
210302	Түлш, халаалт	6,583,161.00	6,436,011.00
210303	Цэвэр, бохир ус	5,133,718.00	2,165,031.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,484,819.56	1,028,600.00
210401	Бичиг хэрэг	306,100.00	444,400.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	827,530.00	143,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	114,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	637,300.00	265,600.00
210408	Бараа материал акталсны зардал	6,713,889.56	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	47,399,550.00	21,532,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	47,400.00
210502	Хоол, хүнс	47,399,550.00	21,208,275.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	276,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,018,800.00	758,000.00
210604	Урсгал засвар	1,018,800.00	758,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	150,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	00.00



**Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	462,000.00	290,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	282,000.00	50,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,307,215.84	25,478,167.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	406,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	192,700.00	46,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,708,515.84	25,431,767.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,433,521.31	9,570,611.31
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,107,000.00	94,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,107,000.00	94,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,326,521.31	9,476,511.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,326,521.31	9,476,511.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>111,494,839.60</b>	<b>-13,583,337.69</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>111,494,839.60</b>	<b>-13,583,337.69</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>308,055,700.00</b>	<b>327,841,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>308,055,700.00</b>	<b>327,841,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,895,600.00	311,086,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,698,000.00	140,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	198,000.00	140,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,462,100.00	16,615,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,462,100.00	16,615,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>308,055,700.00</b>	<b>327,841,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>308,055,700.00</b>	<b>327,841,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>305,622,178.69</b>	<b>318,270,588.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	206,684,403.00	244,483,900.00
210101	Үндсэн цалин	172,198,562.00	189,280,738.41
210102	Нэмэгдэл	17,134,248.00	35,991,691.64
210104	Урамшуулал	17,351,593.00	19,211,469.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,783,485.69	32,095,358.69
210201	Тэтгэврийн даатгал	17,515,685.69	23,694,783.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,066,900.00	2,094,919.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,653,600.00	1,676,075.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,400.00	439,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,133,900.00	4,189,937.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,921,110.00	14,385,925.00
210301	Гэрэл, цахилгаан	4,204,231.00	2,834,883.00
210302	Түлш, халаалт	6,583,161.00	9,386,011.00
210303	Цэвэр, бохир ус	5,133,718.00	2,165,031.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,587,070.00	1,258,600.00
210401	Бичиг хэрэг	594,700.00	343,900.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	827,530.00	143,900.00
210404	Ном, хэвлэл	3,664,840.00	125,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	114,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	470,600.00



Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,153,450.00	23,472,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153,900.00	472,200.00
210502	Хоол, хүнс	47,399,550.00	21,891,005.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	1,109,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,299,800.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	1,299,800.00	1,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	150,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	698,500.00	434,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	518,500.00	194,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,344,360.00	940,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	406,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	938,360.00	690,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,433,521.31</b>	<b>9,570,611.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,107,000.00	94,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,107,000.00	94,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,326,521.31	9,476,511.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,326,521.31	9,476,511.31
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,530,130.97	465,702,989.92	-61,792,660.93	812,440,459.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>408,530,130.97</b>	<b>465,702,989.92</b>	<b>-61,792,660.93</b>	<b>812,440,459.96</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	111,494,839.60	111,494,839.60
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>408,530,130.97</b>	<b>465,702,989.92</b>	<b>49,702,178.77</b>	<b>923,935,299.66</b>
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>408,530,130.97</b>	<b>465,702,989.92</b>	<b>49,702,178.77</b>	<b>923,935,299.66</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>408,530,130.97</b>	<b>465,702,989.92</b>	<b>49,702,178.77</b>	<b>923,935,299.66</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-13,583,337.69	-13,583,337.69
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>408,530,130.97</b>	<b>465,702,989.92</b>	<b>36,118,841.08</b>	<b>910,351,961.97</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	331,090,100.00	318,224,688.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,090,100.00	318,224,688.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,996,000.00	318,130,588.69
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	245,889,600.00	244,483,900.00
210101	Үндсэн цалин	191,984,500.00	189,280,738.41
210102	Нэмэгдэл	37,181,000.00	35,991,691.64
210104	Урамшуулал	16,724,100.00	19,211,469.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,735,900.00	32,095,358.69
210201	Тэтгэврийн даатгал	20,900,600.00	23,694,783.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,458,700.00	2,094,919.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,967,100.00	1,676,075.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491,800.00	439,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,917,700.00	4,189,937.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,465,200.00	14,385,925.00
210301	Гэрэл, цахилгаан	2,875,300.00	2,834,883.00
210302	Түлш, халаалт	9,375,100.00	9,386,011.00
210303	Цэвэр, бохир ус	2,214,800.00	2,165,031.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,451,000.00	1,118,600.00
210401	Бичиг хэрэг	203,900.00	203,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,900.00	143,900.00
210404	Ном, хэвлэл	125,500.00	125,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	500,100.00	114,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	964,600.00	470,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,888,700.00	23,472,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	472,200.00	472,200.00
210502	Хоол, хүнс	32,538,000.00	21,891,005.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	878,500.00	1,109,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,150,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	2,150,000.00	1,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х</b>	475,300.00	434,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	235,300.00	194,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	940,300.00	940,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,300.00	690,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	94,100.00	94,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	94,100.00	94,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,100.00	94,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	331,090,100.00	327,701,200.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	314,474,900.00	311,086,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,474,900.00	311,086,000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	16,615,200.00	16,615,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,615,200.00	16,615,200.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>140,000.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,000.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>140,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>140,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Бадраа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ноос 2021 оны 02 дүгээр сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Оюунхэрлэн хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 1-р цэцэрлэг 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хэрлэн сумын 1-р цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 346,533.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 6,933.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,583.3 мянган төгрөгөөр буюу 1.47 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	2,639.0	2,639.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	99,714.6	103,220.2	3,505.8
Үндсэн хөрөнгө	824,220.7	807,131.7	-17,089.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>923,935.3</b>	<b>912,991.0</b>	<b>-10,944.3</b>
Өр төлбөр	-	2,639.0	2,639.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	923,935.3	910,352.0	-13,583.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>923,935.3</b>	<b>912,991.0</b>	<b>-10,944.3</b>

Авлага дансны үлдэгдэл 2,639.0 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 103,220.2 мянган төгрөг болж 3,505.8 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 807,131.7 мянган төгрөг болж 17,089.0 мянган төгрөгөөр буурсан нь ИТХ-ын тогтоолын дагуу үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Урсгал төсвийн худалдан авалтаар 3,094.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5,248.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 14,729.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,639.0 мянган төгрөг болж өссөн нь ажилчдын цалингаас суутгасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 910,352.0 мянган төгрөг болж 13,583.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 113,430.0 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 11,648.1 мянган төгрөгөөр буюу 3.36 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, нормативт зардал, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлууд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 331,090.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 331,090.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 331,090.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 331,090.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 314,474.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 16,615.2 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 311,086.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16,615.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 327,701.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 318,224.7 мянган төгрөгийг зарцуулж 9,476.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 318,224.7 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь нормативт зардал 10,416.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1,332.4 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 950.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс үүдэлтэй бөгөөд энэ нь цаг үеийн нөхцөл байдлаас болж үйл ажиллагаа бүрэн явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон тендерийн орлого 140.0 мянган төгрөг орсныг бичиг хэргийн зардалд зарцуулжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс бүгдийг хугацаанд нь оруулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-			
Албан шаардлага	1	15,000.0	1	15,000.0			
Зөвлөмж	-	-	-	-			
Нийт дүн	1	15,000.0	1	15,000.0			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,554.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 7,435.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 118.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт хүргүүлсэн.

#### Залруулсан алдаа

Аудитаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцож татварт төлсөн 2,639.0 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийж татвараас авлага үүсгэж, хувь хүнд өглөг үүсгүүлсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 7,554.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлээ.

Үүнд:

1. Бараа материалын үлдэгдэлд жилийн эцсийн тооллого хийгээгүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтны цалингийн орлогоос нийт 2,639.0 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд 118.2 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг тендерийн үнээс илүү үнээр худалдаж авсан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41-р зүйлийн Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох хэсгийн 41.1.2.энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хэрлэн сумын 1-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/69/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрлэн сумын 1-р цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тендерийн үнээс илүү үнээр худалдан авсан хүнсний материал	118.2	Төлбөрийн акт тогтоох	Эрхлэгч, нягтлан бодогч	Г.Бадраа, Л.Өнөржаргал
2	Жилийн эцсийн тооллого хийгээгүй бараа материалын үлдэгдэл	4,796.8	Албан шаардлага	Эрхлэгч, нягтлан бодогч	Г.Бадраа, Л.Өнөржаргал
3	Хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан.	2,639.0	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Г.Бадраа, Л.Өнөржаргал
<b>ДҮН</b>		<b>7,554.0</b>			

